БАТЛАВ.
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны ... дугаар сарын ...

# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШИЛ, ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛОЛ ДУНДАХ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР (2 бүс)

2024 оны 03 дугаар сарын 20 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Ажил гүйцэтгэх үндэслэл | Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны “Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай” 80 дугаар тогтоол; |
| 2. | Ажлын цар хүрээ | Баянзүрх дүүргийн нийтийн эзэмшил, орон сууц, гэр хороолол дундах гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээг хийж, хэвийн найдвартай ажиллагааг хангах; |
| 3. | Байршил | Баянзүрх дүүргийн нийтийн эзэмшил, орон сууц, гэр хороолол дундах гэрэлтүүлгийн ашиглалт, засвар арчлалт (Хоёрдугаар “С” бүс, Дүүргийн 8, 9, 10, 11, 12, 16, 17, 19, 20, 23, 24, 28, 33, 34, 35, 37, 38, 39, 40 дүгээр хороод; |
| 4. | Үндсэн засвар үйлчилгээ | - Гэрэлтүүлгийн толгой засвар үйлчилгээ<br>- Хамгаалах тоноглолуудын засвар үйлчилгээ<br>- Тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ<br>- Паспортжуулах үйлчилгээ<br>- Шуурхай байдлыг хангах үйлчилгээ<br>- Газар шорооны ажил гүйцэтгэх үйлчилгээ<br>- Суурилуулалт, угсралт, солих үйлчилгээ<br>- Гэрэлтүүлгийн самбар, эд анги тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ<br>- Гэрэлтүүлгийн шонгийн засвар үйлчилгээ<br>- Гэрэлтүүлгийн шонгийн өнгө үзэмжийг сайжруулах, сэргээн засварлах үйлчилгээ<br>- Гэрэлтүүлгийн кабелийн засвар үйлчилгээ<br>- Дүүргийн цэцэрлэгт хүрээлэн, тохижилт, тоглоомын талбайн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ<br>- Асалтын түвшин, гэрэлтүүлгийг цагийн хуваарийн дагуу ажиллуулах цагийн тохиргоо хийх үйлчилгээ<br>- Нэгдсэн удирдлагын хяналтын системийн ашиглалтын байдал, гэрэлтүүлгийн удирдлагын самбарын мэдээллийг үнэн зөв оруулах, тухай бүр шинэчлэн ажиллах<br>- Хүний нөөц, машин механизм, тоног төхөөрөмжийн хүчин чадал |
| 5. | Ашиглалт үйлчилгээний байгууллагын мөрдөх норм, стандарт | **Хуулиуд:**<br>- Эрчим хүчний тухай хууль;<br>- Барилгын тухай хууль;<br>- Газрын тухай хууль;<br>- Бусад холбогдох хууль тогтоомжууд;<br>**Норм, стандарт:**<br>- Гэрэлтүүлэгт тавих ерөнхий шаардлага UCS1902B:2022 хотын стандартыг мөрдөх;<br>- Гэрэлтүүлэх, төхөөрөмжийг байрлуулах, суурилуулах, технологийн удирдамж UCS1902A:2022 хотын стандартыг мөрдөх;<br>- Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03 |

<table>
<tr><td></td><td></td><td>- Цахилгаан техникийн ажил БНбД3.05.06-90;<br>- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНбД13-04-03;<br>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-10-04);<br>- Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх (БД 30-102-11);<br>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг (БНбД 23-02-08);<br>- Автоматжуулалтын систем БНбД 3.05.07-90;<br>- Цахилгаан техникийн тоноглол, хэрэгсэл, хэмжих багаж автоматикын тохируулга, зүгшрүүлэлтийн ажлын төсвийн норм БНбД 81-85-16;<br>- Бусад холбогдох журам, норм, дүрэм, зааврыг мөрдлөг болгож ажиллах;</td></tr>
<tr><td>6.</td><td>Ажлын тоо хэмжээ</td><td>Дүүргийн 19 хороодын нутаг дэвсгэрийн гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцна.
<table>
<tr><th>д/д</th><th colspan="2">Ажлын нэр, төрөл</th><th>Орон сууц</th><th>Гэр хороолол</th><th>Нийтийн эзэмшил</th><th>Нийт тоо</th></tr>
<tr><td>1.</td><td colspan="2">Гэрэлтүүлгийн шон</td><td>173</td><td>8494</td><td>843</td><td>9510</td></tr>
<tr><td>2.</td><td colspan="2">Гэрэлтүүлгийн толгой</td><td>173</td><td>8494</td><td>1248</td><td>9915</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="2">Газрын кабель АББВ 3*25+16мм2</td><td>150</td><td>3180</td><td>12090</td><td>15420</td></tr>
<tr><td>4.</td><td colspan="2">Агаарын болон СИП 3х16+1х24мм2</td><td>4844</td><td>237832</td><td>13200</td><td>255876</td></tr>
<tr><td>5.</td><td rowspan="2">Гэрэлтүүлгийн самбар</td><td>Төвлөрсөн удирдлагатай</td><td>3</td><td>106</td><td>31</td><td>140</td></tr>
<tr><td>6.</td><td>Цагийн релейтэй</td><td>2</td><td>-</td><td>2</td><td>4</td></tr>
</table></td></tr>
<tr><td>7.</td><td>Ашиглалт үйлчилгээний байгууллагад тавих шаардлага</td><td>Тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагыг тендер зарлан шалгаруулна.</td></tr>
<tr><td>8.</td><td>Онцгой нөхцөл</td><td>Дүүргийн нийтийн эзэмшил, орон сууц, гэр хороолол дундах гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд дараах онцгой шаардлага тавина.<br>-Цахилгаан угсралт, засвар үйлчилгээний чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг туршлагатай, бригадын системд оруулж ажиллах боломжтой хүний нөөц, техник, тоног төхөөрөмж хангагдсан байх;<br>-Хот нийтийн аж ахуйн чиглэлээр ашиглалт засвар үйлчилгээний ажлын туршлагатай;<br>-Бусад газрын ашиглалтад хариуцсан байгууллага биш байх;</td></tr>
<tr><td>9.</td><td>Ажиллах хүч</td><td>- Ерөнхий инженер<br>- Цахилгааны инженер<br>- ХАБЭА-н ажилтан<br>- Цахилгаанчин<br>- Гагнуурчин<br>- Оосорлогч, дохиочин<br>- Жолооч, оператор буюу кранист</td></tr>
<tr><td>10.</td><td>Машин механизм, тоног төхөөрөмж</td><td>Өргөх буулгах машин механизм<br>- Авто кран /5тн-оос дээш, 12м-ээс дээш сунадаг/<br>- Ачааны машин 3-5тн<br>- Шаттай машин автовишка<br>- Яаралтай үйлчилгээнд явах автомашин<br>- Гагнуурын трансформатор<br>- Дөрөө, бүс холбогдох төхөөрөмж<br>- Хүчдэл гүйдэл хэмжигч хэмжүүрийн багаж</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | - Амперклеш<br>- Зөөврийн гагнуурын аппарат<br>- Зөөврийн цахилгаан үүсгүүр<br>- Босоо нягтруулагч<br>- Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлгийн иж бүрдэл |
| 11. | Ерөнхий шаардлага | - Өдөр тутмын үйл ажиллагаа, ашиглалтын үед зайлшгүй хөтлөгдөх, техникийн баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах<br>- Нийт ажилтнуудыг сургалтад хамруулах, тэдэнд зааварчилгаа өгөх, тэднээс мэдлэгийн шалгалт авах,<br>- Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах бүхий л төрлийн ажлыг аюулгүй гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн техникийн үзлэг үйлчилгээ, төлөвлөгөөт Урьдчилан сэргийлэх засвар, туршилтын ажлыг цаг тухайд нь чанартай гүйцэтгүүлэх<br>- Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг тооцох ба түүний хэрэглээ зарцуулалтад тавих хяналтын ажлыг зохион байгуулах<br>- Цахилгаан эрчим хүчийг зүй зохистой хэрэглэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхэд оролцох<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн хамгаалах хэрэгсэл, гал унтраах багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон тэдгээрт үзлэг шалгалт, туршилтын цаг хугацаанд нь хийж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.<br>- Шинээр ашиглалтад оруулж байгаа болон өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн тоног төхөөрөмжийг ажилд залгаж ашиглах журмыг хэрэгжилтийг хангуулах<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээ болон аваарын байдлыг хэвийн горимд оруулах ажлыг шуурхай зохион байгуулах<br>- Гэрэлтүүлгийн ажлын схем зураг бодит байдалтайгаа тохирч буй эсэхийг шалгах /2 жилд 1-ээс доошгүй удаа/, заавар, схем зургийг хянаж үзэх /3 жилд 1-ээс доошгүй удаа/, цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлтийг хэмжиж хянах /2 жилд 1-ээс доошгүй удаа/, цахилгаан техникийн ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх /5 жилд 1-ээс доошгүй удаа/ зэрэг ажлуудыг зохион байгуулах |

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.АЛТАНЗАЯА